



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 1/182

Чингис хот

“МАЛ МАХ” нэгдсэн арга хэмжээ
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн “а”, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.3, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх захиргааны зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хөдөө орон нутгаас нийслэл, төв суурин газарт мал мах малын гаралтай түүхий эд хууль бусаар тээвэрлэн ирж байгаа, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Мал мах” нэгдсэн арга хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс мөн 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл 45 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. “Мал мах” нэгдсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулж, томилогдсон ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж ажиллахыг сумын Засаг дарга, тосгодын Захирагч нарт, аймгийн Цагдаагийн газрын дарга /хурандаа Б.Батсайхан/, Мал эмнэлгийн газрын дарга /Н.Анхбаяр/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010311